


2017 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



Иргэдийг цэвэр усаар найдвартай хангах зорилгоор Оюу Толгой ХХК нь Өмнөговь аймгийн Ханбогд суманд “Цэвэр ус хангамжийн цогцолбор”-ыг 2017 оны 4-р сард барьж, орон нутагт нь хүлээлгэн өгсөн байна. Нийт 6.9 сая ам долларын хөрөнгө оруулалтаар боссон энэхүү цогцолбор нь 13 мянган хүнийг цэвэр усаар хангах хүчин чадалтай бөгөөд цогцолборын хүчин чадлыг цаашид нэмэгдүүлэх боломжтой юм.



Эрдэнэ Монгол ХХК Тэхийн талын тунхаглалын дагуу Баянхонгор аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран Говийн гайхамшигт 6 амьтныг хамгаалах ажлын хүрээнд Толь булгийн артезийн цооногийг ашиглан хөв цөөрөм байгуулсан.



Саусгоби Сэндс ХХК нь биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын эхлэл болгож Тост, Тосон бумбын нуруунд нэн ховор амьтны амьдрах орчныг тэтгэх зорилгоор хүний оролцоогүй нарны эрчим хүчээр ажиллах автомат ажиллагаатай уст цэг, худаг гаргажээ.



МАК ХХК нь ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн засвар үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, шаардлагатай сургалтанд хамрагдсан. Ногоон байгууламжийн дуслын усалгааны системийг шинэчилж уурхайн шүүрлийн усны насосонд тоолуур суурилуулжээ.

2018 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТУУД



- Санал гомдлын механизм сайжруулан албажуулах (Гоби Коул энд Энержи)
- Сав газрын захиргаатай хамтран газрын доорх усны мониторинг мэдээллийг орон нутагт танилцуулах (Саус Гоби Сэндс, Энержи Ресурс)



- Хариуцлагатай уул уурхайн стандартууд бүх үйл ажиллагаа явуулж буй уурхайнууддаа нэвтрүүлэх (Эрдэнэс Монгол)
- Сав Газрын Захиргаанд тайлагнах механизмыг сайжруулах (бүх гишүүн компаниуд)



- Залуучууд болон ТББ-ыг хамтын мониторингийн хөтөлбөрт хамруулах (Оюу Толгой)



- Зөвхөн цэвэршүүлсэн саарал усыг тоосжилт дарахад ашиглах (Баян Айраг)
- Хамгийн багадаа 2 хяналтын цооног байгуулах (Эрдэнэс Таван Толгой, МАК)



- Зэрлэг ан амьтадад зориулсан уст цэг байгуулах (МАК)



- Орон нутгийн иргэдэд шинэ хоёр худаг гаргах (Эрдэнэ Монгол)
- Худаг сэргээн засварлах (Гоби коул Энержи, Оюу Толгой)



САЙН ДУРЫН КОДЕКС: ӨМНИЙН ГОВЬ ДАХЬ УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫН УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН САЙН ДУРЫН ЗАРЧМУУД



Gobi Coal and Energy



САЙН ДУРЫН КОДЕКС: ӨМНИЙН ГОВЬ ДАХЬ УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫН УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН САЙН ДУРЫН ЗАРЧМУУД

ЭРХЭМ ЗОРИЛГО

Усаар хангагдах нь хүний үндсэн эрх гэдгийг хүлээн зөвшөөрч, хариуцлагатай бөгөөд хууль журмыг чандлан биелүүлсэн усны тогтвортой ашиглалт бий болгох сайн дурын амлалтыг бид авч байна. Бид усыг үр ашигтай ашиглахын зэрэгцээ өөрсдийн усны менежментийн үйл ажиллагаанд оролцооны зарчмуудыг ханган ажиллах болно.


Уул уурхайн нэр бүхий 10 компани 2016 оны 2-р сард усны тогтвортой менежментийн Сайн Дурын Кодекс (СДК)-т нэгдэн орсноор өмнийн говь нутагт усны үр ашигтай, ил тод хэрэглээг бий болгох хамтын үүрэг амлалт авсан билээ. Усны менежментийн СДК нь ус бол нийтээр хэрэглэх нөөц баялаг бөгөөд усны менежментэд хамтын оролцооны шаардлага байгааг зөвшөөрсөн баримт бичиг болсон юм. Энэхүү кодекст нэгдсэнээр дээрх уул уурхайн компаниуд нь төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж усны хомсдлыг бууруулах, усны нөөцийн тогтвортой хэрэглээг орон нутгийн түвшинд бий болгоход дэмжлэг үзүүлэх үүрэг амлалтуудыг авсан болно.

СДК-Д НЭГДСЭН КОМПАНИУД 2017 ОНД:



ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН 2017 ОНЫ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Компани тус бүрийн дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл <https://www.commddev.org/south-gobi-water-and-mining-industry-roundtable/> цахим хаягаар хандана уу.